



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ



# БИЗНЕС ИТГЭЛИЙН ИНДЕКС 2021

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгааны институт  
Улаанбаатар хот, 2022



## АГУУЛГА

<b>ХУРААНГУЙ</b> .....	2
<b>I. Бизнес итгэлийн индекс</b> .....	3
1.1 Бизнесийн орчны үнэлгээ, хүлээлт.....	5
1.2 Хөрөнгө оруулалтын орчин .....	7
1.3 Ажил эрхлэлт, үнийн өсөлт, ядуурал .....	8
1.4 Бизнесийн үйл ажиллагаа .....	10
<b>II. Бизнес тулгамдаж буй гол асуудлууд</b> .....	21
<b>III. Судалгааны арга зүй, оролцогчийн мэдээлэл</b> .....	22

## ХУРААНГУЙ

МҮХАҮТ-аас Бизнес итгэлийн индекс судалгааг 2001 оноос хойш жил бүр тасралтгүй хийж байна. 2021 оны бизнес итгэлийн индекс судалгаа нь олон улсын харилцаа, гадаад худалдааны тодорхойгүй, тааламжгүй орчин нөхцөл үүссэн, дотооддоо цар тахлын дараа бизнес, эдийн засгаа сэргээх амаргүй цаг үед хийгдсэнээрээ онцлог байв.

Судалгаанд Улаанбаатар хот, орон нутгийн нийт 1416 аж ахуйн нэгжийг хамруулан үр дүнг нэгтгэв. Бизнес итгэлийн индексийн өөрчлөлтийг олон улсын туршлагаар эдийн засгийн гол салбаруудаар үнэлэн үр дүнг нэгтгэн танилцуулж байна. Судалгаанд бизнесийн ерөнхий орчин, бизнесийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын орчин, макро үзүүлэлт гэсэн үндсэн 4 хэсгийн нийт 12 үзүүлэлтүүдэд тулгуурлан индексийг тооцсон.

2021 оны Бизнес итгэлийн индекс -0.05 үнэлгээтэй гарсан ба өмнөх оны үнэлгээнээс 0.23 пунктээр өссөн дүн юм. Эдийн засгийн гол салбаруудаар авч үзвэл барилга, үйлчилгээний салбарын бизнес эрхлэгчдийн бизнесийн орчинд итгэх итгэл хамгийн бага байна.

Бизнес итгэлийн индекс тооцдог үзүүлэлтүүдээр нарийвчлан авч үзвэл бизнесийн орчин 2020 оноос муудсан гэж бизнес эрхлэгчид үзэж байгаа бөгөөд 2021 онд бизнесийн орчин сайжрах тухай бизнес эрхлэгчдийн хүлээлт өмнөх оноос буурсан байна.

Харин 2021 онд хөрөнгө оруулалтын орчны индекс 0.11 үнэлгээтэй ба бизнес эрхлэгчдийн хөрөнгө оруулалтын орчинд итгэх итгэл сэргэсэн байна. Эдийн засгийн гол салбаруудаар авч үзвэл 2021 онд хөрөнгө оруулалтын орчинд хөдөө аж ахуйн салбарын бизнес эрхлэгчид хамгийн бага үнэлгээг өгсөн бол үйлдвэрлэлийн салбар хамгийн сайн үнэлгээг өгчээ. Мөн 2022 онд хөрөнгө оруулалтын орчин 2021 онтой ойролцоо түвшинд байна гэж бизнес эрхлэгчид таамаглаж байна.

2021 онд бизнесийн үйл ажиллагааны индекс -0.26 үнэлгээтэй гарсан ба энэ нь өмнөх оноос 0.16 пунктээр өссөн дүн байна. Худалдаа, барилга, үйлдвэрлэлийн салбарын бизнес эрхлэгчид бизнесийн үйл ажиллагаа явуулахад илүү хүндрэлтэй байна гэж үзэж, хамгийн бага үнэлгээ өгсөн. Судалгаанд оролцсон нийт аж ахуйн нэгжүүдийн хувьд бизнесээ өргөжүүлэхэд санхүүжилттэй холбогдох асуудлууд, бараа материал түүхий эдийн үнэ, олдоц, ажиллах хүчний хомсдол хамгийн сөрөг нөлөөтэй байна гэжээ.

Бизнес эрхлэгчид 2021 онд бизнесийн орчинд нэн тэргүүнд шийдвэрлэх асуудлаар “Татварын хувь, хэмжээ (ААНОАТ, НӨАТ гэх мэт)”-г онцолсон бол “Бодлогын тогтворгүй байдал” болон “Зээлийн өндөр хүү, хугацаа” зэрэг асуудлууд мөн бизнесийн орчныг сайжруулахад нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай гэжээ.

## I. Бизнес итгэлийн индекс

Бизнесийн ерөнхий орчин, бизнесийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын орчин, макро үзүүлэлт гэсэн гол 4 бүрэлдэхүүн хэсгийн нийт 12 үзүүлэлтүүдэд тулгуурлан бизнес итгэлийн индексийг тооцсон.

2021 оны Бизнес итгэлийн индекс -0.05 үнэлгээтэй гарсан нь өмнөх оны үнэлгээнээс 0.23 пунктээр өссөн байна. (Зураг 1)

Зураг 1. Бизнес итгэлийн индекс (2012-2021)



Бизнес итгэлийн индексийг тооцдог үзүүлэлтүүдээр нарийвчлан авч үзвэл бизнесийн үйл ажиллагаа, бизнесийн орчин 2020 оноос муудсан гэж бизнес эрхлэгчид үзсэн ба эдгээртэй холбогдох дэд үзүүлэлтүүд хамгийн бага үнэлгээ авсан. Макро эдийн засгийн орчин, хөрөнгө оруулалтын орчин өмнөх оноос бага зэрэг сайжирсан гэж үзсэн ба эерэг үнэлэгдсэн байна. (Хүснэгт 1)


Хүснэгт 1. 2021 оны Бизнес итгэлийн индекс, дэд үзүүлэлтүүдээр

Үзүүлэлт		Индекс
<b>1</b>	<b>Бизнесийн орчны өөрчлөлтийн үнэлгээний индекс</b>	<b>(0.24)</b>
<b>2</b>	<b>Бизнесийн үйл ажиллагааны үнэлгээний индекс</b>	<b>(0.26)</b>
2.1	Үйлдвэрлэлийн хэмжээний өөрчлөлт (бизнесийн үйл ажиллагааны өөрчлөлт)	(0.35)
2.2	Бараа бүтээгдэхүүний эрэлтийн өөрчлөлт (захиалгын хэмжээ)	(0.32)
2.3	Борлуулалтын орлогын өөрчлөлт	(0.04)
2.4	Санхүүгийн үзүүлэлт	(0.34)
<b>3</b>	<b>Хөрөнгө оруулалтын орчны үнэлгээний индекс</b>	<b>0.11</b>
<b>4</b>	<b>Макро үзүүлэлтүүдийн өөрчлөлтийн индекс</b>	<b>0.21</b>
4.1	Ажиллагсдын тоо	(0.14)
4.2	Бараа бүтээгдэхүүний дундаж үнэ	0.41
4.3	Ядуурлын түвшин	0.37
<b>БИЗНЕС ИТГЭЛИЙН ИНДЕКС</b>		<b>(0.05)</b>

Дэд үзүүлэлтүүдийн сүүлийн 3 жилийн үнэлгээг харьцуулан авч үзвэл 2020 онд хөрөнгө оруулалтын өөрчлөлтийн үнэлгээ, макро эдийн засгийн үзүүлэлтүүд сөрөг үнэлгээтэй байсан бол 2021 онд эдгээр үнэлгээнүүд бүгд эерэг болж өөрчлөгдсөн. Харин бизнесийн орчны үнэлгээ, бизнесийн үйл ажиллагаатай холбогдох үнэлгээнүүд өмнөх жилээс сайжирсан ч сөрөг үнэлгээтэй байгаа нь бизнесийн орчин, бизнесийн үйл ажиллагаанд шийдвэрлэх асуудлууд байсаар байгааг илтгэж байна.

2021 онд дэд үзүүлэлтүүдээс бизнесийн үйл ажиллагааны үнэлгээ, макро эдийн засгийн үзүүлэлтүүд хамгийн их нэгж пунктээр сайжирсан байна. (Зураг 2).


*Зураг 2. 2019-2021 оны Бизнес итгэлийн индекс, дэд үзүүлэлтүүдээр*



Бизнес итгэлийн индексийн үнэлгээг эдийн засгийн гол салбаруудаар нь ангилан авч үзвэл барилга, хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарын бизнес эрхлэгчдийн бизнесийн орчинд итгэх итгэл улсын дунджаас бага байна. Харин эдийн засгийн гол салбаруудын үнэлгээг 2020 оны үнэлгээтэй харьцуулан авч үзвэл салбар бүрийн хувьд бизнесийн орчинд итгэх итгэл нь өссөн дүнтэй ба үүнээс барилгын салбар 0.26 пункт, үйлдвэрлэлийн салбар 0.23 пунктээр өссөн нь хамгийн их өсөлттэй салбар болж байна.

Бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа байршлаар нь харвал 2021 оны хувьд Улаанбаатар хот болон орон нутагт үйл ажиллагаагаа явуулдаг бизнес эрхлэгчид ойролцоо үнэлгээ өгсөн байна. (Зураг 3)

*Зураг 3. 2020 ба 2021 оны Бизнес итгэлийн индекс, эдийн засгийн гол салбараар, байршлаар*




### 1.1 Бизнесийн орчны үнэлгээ, хүлээлт

2021 онд бизнес эрхлэх орчин өмнөх жилээс хэрхэн өөрчлөгдсөн тухайд тодруулдаг бизнесийн орчны өөрчлөлтийн индекс -0.24 үнэлгээтэй ба өмнөх жилээс бизнесийн орчин муудсан гэж бизнес эрхлэгчид үзэж байна.

2021 онд эдийн засгийн гол салбаруудаар авч үзвэл бүх салбарт сөрөг үнэлгээтэй ба өмнөх жилтэй харьцуулбал үйлдвэрлэлийн салбар 0.15, худалдааны салбар 0.13, барилгын салбар 0.14, хөдөө аж ахуйн салбар 0.27, үйлчилгээний салбарын үнэлгээ нь 0.25 пунктээр тус тус сайжирсан байна. (Зураг 4)

Зураг 4. Бизнесийн орчны өөрчлөлтийн индекс, салбараар




### Бизнесийн орчны өөрчлөлтийн хүлээлт

Бизнес эрхлэгчдийн дараа жилийн бизнесийн орчныг хэрхэн төсөөлж, таамаглаж байгаа нь эдийн засаг, бизнесийн шийдвэрүүдэд чухал нөлөөтэй, холбогдох бодлого шийдвэр гаргахад анхаарах гол үзүүлэлтүүдийн нэг юм. Бизнес эрхлэгчид бизнесийн орчныг илүү өөдрөгөөр таамаглаж байгаа тохиолдолд бизнестээ ямар нэг хэмжээгээр хөрөнгө оруулалт хийх, шинээр ажлын байр бий болгох, богино хугацааны үйлдвэрлэл, үйл ажиллагаагаа нэмэгдүүлэх зэргээр эдийн засагт шууд болон шууд бус эерэг нөлөөтэй байдаг. Түүнчлэн Бизнес итгэлийн индекс судалгааны бизнесийн орчны талаарх бизнес эрхлэгчдийн хүлээлт нь тухайн жилийн эдийн засгийн өсөлттэй адил трендтэй байдаг.


2020 оны судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 43 хувь нь 2021 онд бизнесийн орчин сайжирна гэсэн хүлээлттэй байсан бол 2021 оны бодит байдалд бизнес эрхлэгчдийн 18 хувь нь сайжирсан үнэлгээ өгчээ. Харин 2022 онд бизнесийн орчин сайжрах тухай бизнес эрхлэгчдийн хүлээлт өмнөх оноос 2 хувиар буурч 41 хувь болжээ. (Зураг 5)

Зураг 5. Бизнесийн орчны өөрчлөлтийн үнэлгээ, хүлээлт



2022 онд бизнесийн ерөнхий орчин хэрхэн өөрчлөгдөх тухай хүлээлтийг эдийн засгийн гол салбаруудаар нь ангилан авч үзвэл хөдөө аж ахуйн болон үйлчилгээний салбарууд сайжрах хүлээлт өндөр байгаа бол барилга худалдааны салбарууд бусад салбаруудтай харьцуулахад бага хүлээлттэй байна. (Зураг 6)

Зураг 6. 2022 онд бизнесийн орчин хэрхэн өөрчлөгдөх тухай хүлээлт, салбараар






## 1.2 Хөрөнгө оруулалтын орчин

Хөрөнгө оруулалтын орчинтой холбогдох үнэлгээ өнгөрсөн онд сөрөг дүнтэй гарсан ч энэ жил 0.11 эерэг үнэлгээтэй гарч бизнес эрхлэгчдийн хөрөнгө оруулалтын орчинд итгэх итгэл сэргэсэн байна.

2021 онд хөрөнгө оруулалтын орчны индекс 0.11 үнэлгээтэй гарсан нь өмнөх оноос 0.14 пунктээр өссөн дүн юм. Эдийн засгийн гол салбаруудаар авч үзвэл 2021 онд хөрөнгө оруулалтын орчинд хөдөө аж ахуйн салбарын бизнес эрхлэгчид хамгийн бага үнэлгээг өгсөн бол үйлдвэрлэлийн салбар хамгийн сайн үнэлгээг өгчээ. Харин өмнөх онтой харьцуулахад үйлдвэрлэлийн салбарын үнэлгээ хамгийн их дүнгээр сайжирсан байна. (Зураг 7)


Зураг 7. Хөрөнгө оруулалтын орчны индекс, салбараар



## Хөрөнгө оруулалтын орчны хүлээлт

Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдээс 2022 онд бизнестээ хөрөнгө оруулалт хийх тухай хүлээлтийг тодруулахад 69.5 хувь нь хөрөнгө оруулалт хийнэ гэсэн эерэг хүлээлттэй байгаа ба энэ нь 2021 оны хүлээлттэй ойролцоо дүнтэй байна. (Зураг 8)

Зураг 8. 2022 онд бизнестээ хөрөнгө оруулалт хийх тухай хүлээлт



### 1.3 Ажил эрхлэлт, үнийн өсөлт, ядуурал

2020 онд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөлөөгөөр эдийн засгийн идэвхжилт буурснаар эрэлтийн нөлөөгөөр инфляцын түвшин 2.3 хувь ба инфляц нам дор түвшинд хадгалагдаж байсан бол 2021 онд шатахууны үнэ, хүнсний бүлгийн үнийн өсөлт, махны нийлүүлэлт буурсан, хилийн хязгаарлалт үүсэж, гадаад худалдааны тээвэр, логистикийн зардал эрчтэй нэмэгдсэн зэрэгтэй холбоотойгоор оны эхний хагас жилийн байдлаар улсын инфляцын түвшин 16.1 хувьд хүрсэн байна.


#### Өөрчлөлтийн үнэлгээ

2021 оны бизнес итгэлийн индекс Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 49.2 хувь нь ажилгүйдлийн түвшин өөрчлөгдөөгүй гэж үзсэн бол 34.4 хувь нь ажилгүйдэл буурсан гэж хариулжээ.

Бараа бүтээгдэхүүний үнэ хэрхэн өөрчлөгдсөн талаар тодруулахад судалгаанд оролцогсдын 65.2 хувь нь өссөн гэж хариулсан.

Мөн бизнес эрхлэгчдийн 56.9 хувь нь ядуурлын түвшин өссөн, 26.1 хувь нь өөрчлөгдөөгүй, 11.6 хувь нь хэлж мэдэхгүй байна гэсэн байна. (Зураг 9)

Зураг 9. Ажилгүйдэл, инфляц, ядуурлын түвшингийн 2021 оны өөрчлөлтийн үнэлгээ




### 2022 онд хэрхэн өөрчлөгдөх тухай хүлээлт

Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдээс 2022 онд ажилгүйдэл, бараа бүтээгдэхүүний үнэ, ядуурлын түвшин хэрхэн өөрчлөгдөх хүлээлттэй байгаа талаар тодрууллаа.


Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжийн 49.2 хувь нь ажилгүйдлийн түвшин өөрчлөгдөхгүй, 14.8 хувь нь буурна, 29.2 хувь нь ажилгүйдлийн түвшин өснө гэжээ. Бараа бүтээгдэхүүний үнэ хэрхэн өөрчлөгдөх тухайд 23.2 хувь нь өөрчлөгдөхгүй, 65.7 хувь нь өснө гэж таамаглаж байна. Харин ядуурлын түвшинг 25.1 хувь нь өөрчлөгдөхгүй, 47.5 хувь нь өснө, 15.5 хувь нь хэлж мэдэхгүй байна гэжээ. (Зураг 10)

Зураг 10. Ажилгүйдэл, инфляц, ядуурлын түвшин 2022 онд хэрхэн өөрчлөгдөх тухай хүлээлт



2022 онд ажиллагсдын тоо хэрхэн өөрчлөгдөх тухайд бизнес эрхлэгчдийн хүлээлтийг эдийн засгийн гол салбаруудаар нь ангилан харвал судалгаанд оролцсон барилгын салбарын бизнес эрхлэгчдийн 22.0 хувь нь ажиллагсдын тоо буурна, хөдөө аж ахуйн салбарын 54.9 хувь нь өөрчлөгдөхгүй гэж таамаглаж байна. Харин үйлдвэрлэлийн салбарын 33.8 хувь нь ажилчдын тоо өснө гэж таамаглаж байна. (Зураг 11)

Зураг 11. 2022 онд ажиллагсдын тооны өөрчлөлтийн хүлээлт, салбараар



### 1.4 Бизнесийн үйл ажиллагаа


Бизнес итгэлийн индекс судалгааг 2020 оноос эхлэн олон улсын туршлага, Үндэсний статистикийн хорооны ДНБ тооцдог ангиллыг харгалзан үйлдвэрлэл, худалдаа, барилга, хөдөө аж ахуй, үйлчилгээ гэсэн үндсэн 5 салбараар үнэлгээг тооцож салбар тус бүрээр бизнесийн үйл ажиллагаа явуулах нөхцөл байдлыг үнэлэн, тулгарч буй хүндрэлийг тодорхойлж байна. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны үнэлгээг ашиг, орлогын түвшин, үйлдвэрлэл, үйл ажиллагааны хэмжээ, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт, санхүүгийн нөхцөл байдал гэсэн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд чухал нөлөөтэй үзүүлэлтүүдээр тооцов.

2021 оны бизнесийн үйл ажиллагааны индекс -0.26 гарсан ба энэ нь өмнөх жилээс 0.16 нэгж пунктээр сайжирсан дүн юм. Эдийн засгийн гол салбаруудаар авч үзвэл худалдаа, барилгын салбарын бизнес эрхлэгчид хамгийн бага үнэлгээг өгсөн. Бизнесийн үйл ажиллагаа явуулж буй байршлаар нь харвал орон нутгийн бизнес эрхлэгчид бизнесийн үйл ажиллагаагаа явуулахад илүү хүндрэлтэй байна гэжээ.

2020 оны бизнесийн үйл ажиллагааны дүнтэй харьцуулахад худалдааны салбарын бизнес эрхлэгчид бизнесийн үйл ажиллагаатай холбогдох үзүүлэлтүүд өмнөх оноос муудсан гэж хариулсан ба 0.02 нэгж пунктээр буурсан. Энэ нь цар тахлын хязгаарлалтын арга хэмжээнээс хамаарсан хилийн хориг, тээвэр логистикийн хүндрэл зэрэг нь бизнесийн үйл ажиллагаанд нь шууд сөргөөр нөлөөлсөн байх талтай юм.

Харин борлуулалтын орлого хэрхэн өөрчлөгдсөн тухай тодруулахад судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 33 хувь нь өссөн гэж хариулсан бөгөөд энэ нь нийт аж ахуйн нэгжүүдийн хувьд өмнөх жилээс 8 хувиар өссөн байна. Борлуулалтын орлогын өөрчлөлтийн эерэг үнэлгээ нь сүүлийн 3 жилд 45 орчим хувьтай байсан юм. (Зураг 12)

Зураг 12. Бизнесийн үйл ажиллагааны индекс (салбараар), борлуулалтын өөрчлөлт



## Үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагааны үнэлгээ



Гол үзүүлэлт	2020 он	2021 он	Өөрчлөлт	%
Үйлдвэрлэл (тэрбум.төг, 2015 з.үнэ)	6,567	6,642	75	1.1%
Ажиллагсдын тоо (мян.хүн)	164	167	3	1.8%
Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоо	8,204	7,547	-657	-8.7%

Эх үүсвэр: 2015 оны зэрэгцүүлэх үнээр Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн хийсэн судлаачийн тооцоолол


Үйлдвэрлэлийн салбарт боловсруулах үйлдвэрлэл, уул уурхай, олборлолт, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн үйлдвэрлэлийн салбарыг нэгтгэн авч үзсэн.

Үйлдвэрлэлийн салбар нь ДНБ-ий 25 хувь, нийт ажиллах хүчний 15 хувийг эзэлдэг томоохон салбар юм. Үндэсний статистикийн хорооны статистик мэдээллийг авч үзвэл 2021 онд салбарын үйлдвэрлэл 6.6 их наяд төгрөг болж өмнөх оноос 1.1 хувиар, ажиллагсдын тоо 167 мянган хүн болж өмнөх оноос 1.8 хувиар өссөн байна.

Нийт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 10 орчим хувь нь үйлдвэрлэлийн салбарт ба 2022 оны 1-р улирлын байдлаар нийт 7.6 мянган аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь өмнөх оноос 8.7 хувиар буурсан дүн юм.


Бизнесийн үйл ажиллагааны дундаж индекс -0.26 байгаа бол үйлдвэрлэлийн салбарын бизнес эрхлэгчид -0.27 үнэлгээ өгсөн ба энэ нь улсын дундажтай ойролцоо үнэлгээтэй байна. Харин өмнөх онтой харьцуулбал 0.25 пунктээр өссөн нь үйл ажиллагааны индексээрээ хамгийн их өсөлттэй салбар болсон байна. (Зураг 13)

Зураг 13. Бизнесийн үйл ажиллагааны индекс



2021 онд судалгаанд оролцсон үйлдвэрлэлийн салбарын бизнес эрхлэгчдийн 55.4 хувь нь үйлдвэрлэлийн хэмжээ буурсан, 61.8 хувь нь бараа бүтээгдэхүүний захиалга, эргэлтийн хэмжээ хэвийн түвшнээс бага байсан гэжээ. Мөн экспортын бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрлэгчдийн хувьд 54.1 хувь нь экспортын захиалга буурсан гэж хариулсан байна. Үйлдвэрийн салбарын бизнес эрхлэгчдийн 42.1 хувь нь борлуулалтын орлогын хэмжээ буурсан, 52.2 хувь нь одоогоор санхүүгийн нөхцөл байдал муу байна гэжээ. (Зураг 14)

Зураг 14. Бизнесийн үйл ажиллагааны нарийвчилсан үнэлгээ



Үйлдвэрийн салбарын бизнес эрхлэгчдийн хувьд үйлдвэрлэлээ өргөжүүлэхэд тулгарч буй бэрхшээлийг тодруулахад давхардсан тоогоор 45.2 хувь нь түүхий эд материалын хомсдол, мөн 45.2 хувь нь төлбөр гүйцэтгэх чадвар, зээлийн нөхцөл гэх мэт санхүүтэй холбогдох асуудал, 36.9 хувь нь ажиллах хүчний хомсдол, 33.8 хувь нь дотоод эргэлтийн хэмжээ зэрэг нь хамгийн их хүндрэл үүсгэж байна гэжээ. 2020 онтой харьцуулахад санхүү, дотоодын эрэлттэй хүндрэл байгаа ба түүхий эд, бараа материалын хомсдолтой холбогдох асуудлууд илүү хүндрэл үүсгэж байна.

(Хүснэгт 2).

Хүснэгт 2. Үйлдвэрлэлээ өргөжүүлэхэд тулгарч буй бэрхшээл

Д/д	Тулгарч буй бэрхшээл	2020	2021
1	Түүхий эд материалын хомсдол	-	45.2%
2	Санхүүгийн асуудал (Төлбөрийн чадваргүй байдал, зээлийн нөхцөл г.м)	50%	45.2%
3	Ажиллах хүчний хомсдол	-	36.9%
4	Дотоодын эрэлт	42%	33.8%
5	Тодорхой бус бизнес, эдийн засгийн орчин	-	33.1%

## Худалдааны салбарын үйл ажиллагааны үнэлгээ



Худалдааны салбарт бөөний болон жижиглэн худалдааны салбарыг нэгтгэн авч үзсэн. Худалдааны салбар нь ДНБ-ий 11 хувь, нийт ажиллах хүчний 13 хувийг эзэлдэг.

Үндэсний статистикийн хорооны статистик мэдээллийг авч үзвэл 2021 онд салбарын борлуулалт 3 их наяд төгрөг болж өмнөх оноос 5.4 хувиар өссөн. Харин нийт ажиллагсдын 13 хувь ба 149 мянган хүн худалдааны салбарт ажиллаж байгаа нь өмнөх оноос 11.7 хувиар буурчээ.


Гол үзүүлэлт	2020 он	2021 он	Өөрчлөлт	%
Борлуулалт (тэрбум.төг, 2015 э.үнэ)	2,797	2,959	162	5.5%
Ажиллагсдын тоо (мян.хүн)	166	149	-17	-11.7%
Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоо	38,547	36,950	-1,597	-4.3%

Эх үүсвэр: 2015 оны зэрэгцүүлэх үнээр Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн хийсэн судлаачийн тооцоолол

2021 оны 4-р улирлын байдлаар нийт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 38 хувь ба 37 мянган аж ахуйн нэгж худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь өнгөрсөн оноос 4.3 хувиар буурсан байна.


Бизнес эрхлэгчдийг бизнесийн үйл ажиллагааны үнэлгээг эдийн засгийн салбараар ангилан авч үзвэл худалдааны салбарт -0.28 үнэлгээтэй ба энэ нь дундаж үнэлгээнээс доогуур үнэлэгдсэн дүн юм. Бизнесийн үйл ажиллагааны дэд индекс бусад салбаруудын хувьд тодорхой хэмжээнд сайжирсан байгаа бол худалдааны салбарын хувьд өмнөх оноос 0.02 пунктээр буурсан дүнтэй байна. (Зураг 15)

Зураг 15. Бизнесийн үйл ажиллагааны индекс



Бизнесийн үйл ажиллагааны үнэлгээг тооцсон дэд үзүүлэлтүүдээр нарийвчлан харвал 2021 онд судалгаанд оролцсон худалдааны салбарын бизнес эрхлэгчдийн 56.5 хувь нь үйлдвэрлэлийн хэмжээ буурсан, 61.7 хувь нь бараа бүтээгдэхүүний нөөц хэвийн түвшнээс бага байна гэжээ. Худалдааны салбарын бизнес эрхлэгчдийн 39.3 хувь нь борлуулалтын орлогын хэмжээ буурсан гэсэн бол 50 хувь нь одоогоор санхүүгийн нөхцөл байдал муу байна гэсэн байна. (Зураг 16)

Зураг 16. Худалдааны салбарын үйл ажиллагааны нарийвчилсан үнэлгээ




Худалдааны салбарын бизнес эрхлэгчдийн хувьд үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд тулгарч буй хүндрэлийг тодруулахад давхардсан тоогоор 46.5 хувь нь банкнаас зээл авах боломж, 45.3 хувь нь санхүүгийн зардал, 43.3 хувь нь хил гаалийн хориг, бусад холбогдох талуудаас шалтгаалан бараа, материалын нийлүүлэлт тогтвортой хийж чадахгүй байгаа зэрэг нь үйл ажиллагаанд хамгийн их хүндрэл үүсгэж байна гэжээ. Өмнөх онтой харьцуулахад банк санхүүгийн байгууллагаас зээл авах боломж, санхүүгийн зардал, худалдан авагчийн эрэлттэй холбогдох хүндрэлүүд хэвээр байгаа бөгөөд 2021 онд бараа материал нийлүүлэлт тасалдах, тогтмол бус байх зэрэг нийлүүлэлттэй холбогдох асуудлууд илүү хүндрэл үүсгэж байна. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Худалдааны салбарын бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд тулгарч буй бэрхшээл

Д/д	Тулгарч буй бэрхшээл	2020	2021
1	Банкнаас зээл авах боломж	44%	46.5%
2	Санхүүгийн зардал	37%	45.3%
3	Нийлүүлэлт	-	43.3%
4	Борлуулалтын хэмжээ	40%	38.8%
5	Эрэлт	-	31.3%



## Барилгын салбарын үйл ажиллагааны үнэлгээ



Барилгын салбар нь ДНБ-ий 3 хувь, нийт ажиллагсдын 7 хувийг эзэлдэг.

Үндэсний статистикийн хорооны статистик мэдээллийг авч үзвэл 2021 онд салбарын үйлдвэрлэл 826 тэрбум төгрөг болж өмнөх оноос 29.6 хувиар буурчээ. Харин нийт ажиллагсдын тоо 82 мянга болж өмнөх оноос 6.1 хувиар өссөн байна.


Гол үзүүлэлт	2020 он	2021 он	Өөрчлөлт	%
Үйлдвэрлэл (тэрбум.төг, 2015 з.үнэ)	1,070	826	-244	-29.6%
Ажиллагсдын тоо (мян.хүн)	77	82	5	6.1%
Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоо	7,818	7,468	-350	-4.7%

Эх үүсвэр: 2015 оны зэрэгцүүлэх үнээр Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн хийсэн судлаачийн тооцоолол

2021 оны 4-р улирлын байдлаар нийт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 10 орчим хувь ба нийт 7.5 мянган аж ахуйн нэгж барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь өмнөх оноос 4.7 хувиар буурсан дүн юм.


Бизнесийн үйл ажиллагааны үнэлгээг салбараар ангилан авч үзвэл барилгын салбарын бизнес эрхлэгчид -0.30 үнэлгээ өгсөн ба эдийн засгийн салбаруудаас барилгын салбарын бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаа явуулахад хамгийн их хүндрэл тулгарч байна гэжээ. Харин өмнөх онтой харьцуулбал барилгын салбарын үйл ажиллагааны индекс 0.19 пунктээр өссөн дүнтэй байна. (Зураг 17)

Зураг 17. Бизнесийн үйл ажиллагааны индекс



Бизнесийн үйл ажиллагааны үнэлгээг тооцсон дэд үзүүлэлтүүдээр нарийвчлан харвал 2021 онд судалгаанд оролцсон барилгын салбарын бизнес эрхлэгчдийн 51.4 хувь нь үйлдвэрлэлийн хэмжээ буурсан, 64.2 хувь нь захиалгат, төлөвлөгөөт үйлдвэрлэлийн хэмжээ хэвийн түвшингээс бага байсан гэжээ. Барилгын салбарын бизнес эрхлэгчдийн 42.2 хувь нь борлуулалтын орлогын хэмжээ буурсан гэсэн бол 58.4 хувь нь одоогоор санхүүгийн нөхцөл байдал муу байна гэсэн байна. (Зураг 18)

Зураг 18. Барилгын салбарын үйл ажиллагааны нарийвчилсан үнэлгээ




Барилгын салбарын бизнес эрхлэгчдийн хувьд үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд тулгарч буй хүндрэлийг тодруулахад давхардсан тоогоор 86.1 хувь нь барилгын материал, түүхий эдийн үнэ, 65.9 хувь нь барилгын материал, түүхий эдийн хомсдол, 56.6 хувь нь ажиллах хүчтэй холбогдох зардлууд хамгийн их бэрхшээл үүсгэж байна гэжээ. 2020 онтой харьцуулахад санхүүгийн зардалтай холбогдох хүндрэлээс илүү барилгын материал, түүхий эдийн олдоц, ажиллах хүчтэй холбогдох хүндрэлүүд 2021 онд илүү бэрхшээл үүсгэж байна гэжээ. (Хүснэгт 4)

Хүснэгт 4. Барилгын салбарын бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд тулгарч буй бэрхшээл

Д/д	Тулгарч буй бэрхшээл	2020	2021
1	Барилгын материал, түүхий эдийн үнэ	57%	86.1%
2	Барилгын материал, түүхий эдийн хомсдол	-	65.9%
3	Ажиллах хүчтэй холбогдох зардлууд	-	56.6%
4	Банкнаас зээл авах боломж	44%	50.3%
5	Тодорхой бус бизнес, эдийн засгийн орчин	-	50.3%

## Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагааны үнэлгээ



Хөдөө аж ахуйн салбарт мал аж ахуй, газар тариалан, бусад хөдөө аж ахуйн салбарыг нэгтгэн авч үзсэн. Хөдөө аж ахуйн салбар нь ДНБ-ий 14 хувь, нийт ажиллагсдын 26 хувийг эзэлдэг Монгол улсын эдийн засгийн суурь салбар юм. Үндэсний статистикийн хорооны статистик мэдээллийг авч үзвэл 2021 онд салбарын үйлдвэрлэл 3.8 их наяд төгрөг болж өмнөх оноос 5.9 хувиар буурсан бол ажиллагсдын тоо 292 мянга болж өмнөх оноос 5.1 хувиар өссөн байна.


Гол үзүүлэлт	2020 он	2021 он	Өөрчлөлт	%
Үйлдвэрлэл (тэрбум.төг, 2015 з.үнэ)	4,019	3,796	-222	-5.9%
Ажиллагсдын тоо (мян.хүн)	277	292	15	5.1%
Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоо	3,480	3,245	-235	-7.2%

Эх үүсвэр: 2015 оны зэрэгцүүлэх үнээр Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн хийсэн судлаачийн тооцоолол

2021 оны 4-р улирлын байдлаар нийт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 4 хувь ба 3.3 мянган аж ахуйн нэгж хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь өмнөх оноос 7.2 хувиар буурсан байна.


Бизнесийн үйл ажиллагааны үнэлгээг эдийн засгийн салбараар нь ангилан авч үзвэл хөдөө аж ахуйн салбарт -0.24 ба дундаж индексээс дээгүүр үнэлгээтэй байна. Харин өмнөх онтой харьцуулбал хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагааны индекс 0.22 пунктээр өссөн үнэлгээтэй байна. (Зураг 19)

Зураг 19. Бизнесийн үйл ажиллагааны индекс



Бизнесийн үйл ажиллагааны үнэлгээг тооцсон дэд үзүүлэлтүүдээр нарийвчлан харвал 2021 онд судалгаанд оролцсон хөдөө аж ахуйн салбарын бизнес эрхлэгчдийн 48.7 хувь нь үйлдвэрлэлийн хэмжээ буурсан, 57.5 хувь нь хөдөө аж ахуйн гаралтай бараа бүтээгдэхүүний эрэлтийн хэмжээ хэвийн түвшингээс бага байсан гэжээ. Хөдөө аж ахуйн бизнес эрхлэгчдийн 32.7 хувь нь борлуулалтын орлогын хэмжээ буурсан гэсэн бол 54.0 хувь нь одоогоор санхүүгийн нөхцөл байдал муу байна гэсэн байна. (Зураг 20)

Зураг 20. Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагааны нарийвчилсан үнэлгээ




Хөдөө аж ахуйн салбарын бизнес эрхлэгчдийн хувьд үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд тулгарч буй хүндрэлийг тодруулахад давхардсан тоогоор 46.0 хувь нь ажиллах хүчний хомсдол, 45.1 хувь нь төлбөрийн чадваргүй байдал, зээлийн нөхцөл гэх мэт санхүүгийн асуудал 38.9 хувь нь дотоод бараа, бүтээгдэхүүний эргэлт зэрэг бэрхшээлүүд хамгийн их хүндрэл үүсгэж байна. Өмнөх онд хамгийн их хүндрэл үүсгэж байсан санхүү, дотоодын эрэлттэй холбогдох асуудлууд мөн адил хүндрэл үүсгэж байгаа бол 2021 онд бизнесийн үйл ажиллагаа сэргэснээр ажиллах хүчний хомсдол хамгийн гол асуудлуудын нэг болжээ. (Хүснэгт 5)

Хүснэгт 5. Хөдөө аж ахуйн салбарын бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд тулгарч буй бэрхшээл

Д/д	Тулгарч буй бэрхшээл	2020	2021
1	Ажиллах хүчний хомсдол	-	46.0%
2	Санхүүгийн асуудал (Төлбөрийн чадваргүй байдал, зээлийн нөхцөл г.м)	50%	45.1%
3	Дотоодын эрэлт	40%	38.9%
4	Түүхий эд материалын хомсдол	-	37.2%
5	Шаардлагатай тоног төхөөрөмж байхгүй байх	-	34.5%

### Үйлчилгээ болон бусад салбарын үйл ажиллагааны үнэлгээ



Үйлчилгээ болон бусад үйл ажиллагааны салбарт зочид буудал, нийтийн хоол, тээвэр, мэдээлэл холбоо, бусад үйлчилгээний салбарыг нэгтгэн авч үзсэн.

Үйлчилгээ болон бусад салбар нь ДНБ-ий 47.5 хувь, нийт ажиллагсдын 39 хувийг эзэлдэг томоохон салбаруудын нэг юм. Үндэсний статистикийн хорооны статистик мэдээллийг авч үзвэл 2021 онд салбарын үйлдвэрлэл 12.9 их наяд төгрөг болж өмнөх оноос 5.2 хувиар өссөн байна.


Гол үзүүлэлт	2020 он	2021 он	Өөрчлөлт	%
Үйлдвэрлэл (тэрбум.төг, 2015 з.үнэ)	12,202	12,869	667	5.2%
Ажиллагсдын тоо (мян.хүн)	479	435	-43	-9.9%
Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоо	37,901	41,126	3,225	7.8%

Эх үүсвэр: 2015 оны зэрэгцүүлэх үнээр Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн хийсэн судлаачийн тооцоолол

Үйлчилгээ болон бусад үйл ажиллагааны салбарт ажиллагсдын тоо нь 435 мянга болж өмнөх оноос 9.9 хувиар буурсан байна. 2021 оны 4-р улирлын байдлаар нийт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 42 хувь ба 41 мянган аж ахуйн нэгж энэ салбарт үйл ажиллагаа явуулж байна.


Бизнесийн үйл ажиллагааны үнэлгээг эдийн засгийн салбараар нь ангилан авч үзвэл үйлчилгээний салбарт -0.24 ба дундаж индексээс дээгүүр үнэлэгдсэн ба өмнөх онтой харьцуулбал 0.22 пунктээр өссөн байна. (Зураг 21)

Зураг 21. Бизнесийн үйл ажиллагааны индекс



Бизнесийн үйл ажиллагааны үнэлгээг дэд үзүүлэлтээр нарийвчлан авч үзвэл 2021 онд судалгаанд оролцсон үйлчилгээний салбарын бизнес эрхлэгчдийн 58.5 хувь нь бизнесийн нөхцөл байдал муу байсан гэжээ. Бараа, үйлчилгээний эргэлтийн хэмжээ буурсан гэж 47.6 хувь нь хариулсан бол 37.1 хувь нь орлогын хэмжээ буурсан гэсэн байна. Мөн үйлчилгээний салбарын судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 49.2 хувь нь одоогоор санхүүгийн нөхцөл байдал муу байна гэж хариулжээ. (Зураг 22)

Зураг 22. Үйлчилгээний ахуйн салбарын үйл ажиллагааны нарийвчилсан үнэлгээ



Үйлчилгээний салбарын бизнес эрхлэгчдийн хувьд үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд тулгарч буй хүндрэлийг тодруулахад давхардсан тоогоор 43.8 хувь нь хүүгийн зардал гэх мэт санхүүгийн зардал, 36.3 хувь нь банкнаас зээл авах боломж, 36.1 хувь нь ажиллах хүчтэй холбогдох зардлууд хамгийн их хүндрэл үүсгэж байна гэжээ.

Бизнес итгэлийн индекс судалгааны 2020 оны үр дүнтэй харьцуулахад өмнөх онд хамгийн их хүндрэл үүсгэж байсан хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн эрэлттэй холбогдох хүндрэл багассан бол санхүүгийн зардал, банк санхүүгийн байгууллагаас санхүүжилт татах боломж бэрхшээл үүсгэсэн хэвээр байна. (Хүснэгт 6)

Хүснэгт 6. Үйлчилгээний салбарын бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд тулгарч буй бэрхшээл

Д/д	Тулгарч буй бэрхшээл	2020	2021
1	Санхүүгийн зардал (хүүгийн зардал г.м)	36%	43.8%
2	Банкнаас зээл авах боломж	26%	36.3%
3	Ажиллах хүчтэй холбогдох зардал	-	36.1%
4	Санхүүгийн асуудал (төлбөрийн чадваргүй байдал, зээлийн нөхцөл г.м)	-	35.4%
5	Эрэлт хангалттай биш	42%	33.5%

## II. Бизнес тулгамдаж буй гол асуудлууд

Бизнесийн орчныг сайжруулахад тулгарч буй асуудлыг тодруулахад судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 65.6 хувь нь татварын хувь хэмжээ, 59.7 хувь нь бодлогын тогтворгүй байдал, 56.7 хувь нь зээлийн хүү өндөр, хугацаа гэсэн асуудлыг хамгийн их саад болж буй нэн тэргүүнд шийдвэрлэх асуудлуудаар нэрлэсэн байна. (Зураг 23)

Зураг 23. Бизнесийн орчныг сайжруулахад нэн тэргүүнд шийдвэрлэх асуудлууд



Бизнесийн орчинд нэн тэргүүнд шийдвэрлэх асуудлыг сүүлийн 5 жилээр нэгтгэн авч үзвэл 2017-2020 онуудад “Зээлийн өндөр хүү, хугацаа” гэсэн асуудлыг хамгийн тулгамдаж буй асуудлаар нэрлэсэн бол 2021 онд “Татварын хувь хэмжээ (ААНОАТ, НӨАТ гэх мэт)”-г хамгийн тулгамдсан асуудлаар нэрлэсэн байна. (Хүснэгт 7)

Хүснэгт 7. Бизнесийн орчныг сайжруулахад нэн тэргүүнд тулгамдаж байгаа гол асуудлууд (2017-2021 он)

Эрэмбэ	2017	2018	2019	2020	2021
1	Зээлийн өндөр хүү / богино хугацаа	Зээлийн өндөр хүү / хугацаа	Зээлийн өндөр хүү, хугацаа	Зээлийн өндөр хүү, хугацаа	Татварын хувь, хэмжээ (ААНОАТ, НӨАТ гэх мэт)
2	Бодлогын тогтворгүй байдал	Бодлогын тогтворгүй байдал	Авилга, хээл хахууль	Бодлогын тогтворгүй байдал	Бодлогын тогтворгүй байдал
3	Татварын хувь, хэмжээ (ААНОАТ, НӨАТ гэх мэт)	Авилга, хээл хахууль	Бодлогын тогтворгүй байдал	Татварын хувь, хэмжээ (ААНОАТ, НӨАТ гэх мэт)	Зээлийн өндөр хүү, хугацаа
4	Хариуцлагагүй, хууль хэрэгжүүлдэггүй байдал	Татварын хувь, хэмжээ (ААНОАТ, НӨАТ гэх мэт)	Хүнд суртал	Авилга, хээл хахууль	Мөнгөний буруу бодлого
5	Авилга, хээл хахууль	Хүнд суртал	Татварын хувь, хэмжээ (ААНОАТ, НӨАТ гэх мэт)	Хүнд суртал	Төрийн байгууллагуудын уялдаа холбоо муу

### III. Судалгааны арга зүй, оролцогчийн мэдээлэл


МҮХАҮТ-аас Бизнес итгэлийн индекс судалгааг 2001 оноос жил бүр тогтмол явуулж байгаа бөгөөд 2020 оноос судалгааг олон улсын бизнесийн итгэлийн индекс, бизнесийн хандлагын судалгаануудын аргачлалыг судлан, эдийн засгийн үндсэн салбаруудаар аргачлалыг шинэчлэн боловсруулж, судалгааг явуулж, үр дүнг боловсруулж байна.

Бизнесийн ерөнхий орчны үнэлгээ, бизнесийн үйл ажиллагааны үнэлгээ, хөрөнгө оруулалтын орчны үнэлгээ, макро эдийн засгийн үзүүлэлтүүд гэсэн 4 дэд үзүүлэлтүүдээр итгэлийн индексийг тооцсон. Бизнесийн үйл ажиллагаатай холбогдох үзүүлэлтийг үйл ажиллагааны хэмжээ, эрэлтийн хэмжээ, борлуулалтын орлого, санхүүгийн нөхцөл байдал зэрэг үзүүлэлтүүдээр тооцож байна.

Судалгааг 2022 оны 4-5 сард Улаанбаатар хот, орон нутгийн бизнес эрхлэгчдийн дунд цахим асуулгын хэлбэрээр явуулж нийт 1416 аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийг хамруулав.

Судалгаанд оролцогчдын түүврийг сонгохдоо аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн үндсэн салбаруудаар түүврийг жигд тархаах зорилгоор нийт үйл ажиллагаа идэвхтэй явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоог салбаруудаар ангилан, түүврийг тооцоолон зорилтот салбарын бизнес эрхлэгчдээс авсан болно.

Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 11.1 хувь нь үйлдвэрлэл, 28.4 хувь нь худалдаа, 12.2 хувь нь барилга, 8.0 хувь нь ХАА, 40.3 хувь нь үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг байна. Борлуулалтын орлогын түвшингээр авч үзвэл 55.4 хувь нь 300 сая төгрөг хүртэл жилийн орлоготой, 23.2 хувь нь 301 саяас 1 тэрбум хүртэл төгрөгийн орлоготой, 21.4 хувь нь нэг тэрбумаас дээш орлоготой байна. Ажиллагсдын тооны хувьд 63.2 хувь нь 19 хүртэл, 31.9 хувь нь 20-199, 4.9 хувь нь 200-аас дээш байна. Мөн бизнесийн насжилтын хувьд 40.3 хувь нь 10-с дээш жил, 23.7 хувь нь 5-10 жил үйл ажиллагаа тасралтгүй явуулж байгаа аж ахуйн нэгжүүд хамрагдсан байна.







## **МҮХАҮТ–ын Судалгааны институт**

Монгол Улс, Улаанбаатар хот 17011,  
Хан–Уул дүүрэг, 15–р хороо, Махатма  
Гандигийн гудамж, МҮХАҮТ–ын байр

**Утас: +976–77277070**

**Факс: +976–11–324620**

 [research@mongolchamber.mn](mailto:research@mongolchamber.mn)